

**ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-104-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

<p align="center"><b>Глайдерын үйл ажиллагааны дүрэм</b> (Шинэчлэгдэж байгаа) /11 хуудас/ 2007 оны NZ amend.5</p>	<p align="center"><b>ПЛАНЕР - ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 7 хуудас (үндсэн дүрэм-16 хуудастай байсан)/1997оны NZ amend.1</p>	<p align="center"><b>Тайлбар</b></p>
<p><b>А Бүлэг — Ерөнхий зүйл</b></p> <p><b>104.1. Зорилго</b> (а) Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) ИНД-91-ийн шаардлагаас гадна, <u>глайдерын</u> үйл ажиллагааны нэмэлт шаардлага; (2) ИНД-43-ын шаардлагаас гадна, <u>глайдерын</u> техник үйлчилгээний нэмэлт шаардлага; (3) ИНД-91-д үл хамаарах <u>глайдерын</u> үйл ажиллагааны шаардлага; (4) ИНД-43-т үл хамаарах <u>глайдерын</u> техник үйлчилгээний шаардлага. (b) Энэ Дүрэм нь ханг-глайдерт хамаарахгүй</p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b></p> <p><b>104.1. Зорилго</b> (а) Энэ дүрмийн зорилго нь: 1/ <u>планерын</u> үйл ажиллагаанд хамаарах ИНД-91-ийн нэмэлт журмыг тогтоох; ба 2/ <u>планерын</u> үйлчилгээнд хамаарах ИНД-43-ын нэмэлт журмыг тогтоох; ба 3/ ИНД-91 болон ИНД-43-ын зарим заалтаас <u>планерын</u> үйл ажиллагааг чөлөөлөхөд тус тус оршино.</p>	<p>-Глайдер-планер болсон.  -Amend.4-өөр өөрчлөгдсөн</p>
<p><b>104.3. Нэр томьёо ба товчлол</b> Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p><b>104.3. Тодорхойлолт</b></p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p><b>104.5. Нисгэгчид тавих шаардлага</b> (а) <u>Глайдерын</u> нисгэгч нь дараах үүрэгтэй: (1) дараах үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшдэг байх: (i) <u>глайдерын</u> нисгэгчийн хүчинтэй үнэмлэх; эсхүл (ii) ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх (<u>глайдер</u>); эсхүл (iii) ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх (глайдер); (2) дараах шаардлагыг хангасан байх: (i) <u>16 нас</u> хүрсэн байх; эсхүл (ii) нислэг бүрд А, эсхүл В <u>категорийн</u> глайдерын Сургагч-нисгэгчээс <u>тусгайлан</u> зөвшөөрөл авсан байх;</p>	<p><b>104.5. Нисгэгчид тавигдах шаардлага</b> (а) <u>Планерын</u> нисгэгч нь: 1/ дараах төрлийн үнэмлэх, гэрчилгээг эзэмшсэн байна: 1.1 <u>планерын</u> нисгэгчийн хүчин төгөлдөр гэрчилгээ, эсхүл 1.2 ИНД-61-ийн дагуу олгогдсон коммерийн нисгэгч (<u>планер</u>)-ийн хүчин төгөлдөр үнэмлэх; болон 2/ дараах шаардлагыг хангасан байна: 2.1 <u>18 нас</u> хүрсэн байх; 2.2 нислэг бүрд А буюу В <u>ангиллын планерын</u> багш нисгэгчээс зөвшөөрөл авсан байх;</p>	<p>-Үнэмлэх, гэрчилгээний төрлийг тодорхой болгосон  -заалт нэмэгдсэн. 18 насыг 16 нас болгосон. ангилал – категори болсон.</p>

<p>(3) <u>нисгэгчийн</u> үнэмлэх, эсхүл гэрчилгээ болон холбогдох зэрэглэлээр олгогдсон эрх, хязгаарлалтыг мөрдөх;</p> <p>(4) глайдерын байгууллагын үйл ажиллагааны стандарт болон журмыг мөрдөх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасныг үл харгалзан, хэрэв тухайн этгээд нь глайдерын байгууллагаас олгосон Сургагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтад глайдерын нисгэгчийн үүрэг гүйцэтгэх бол, энэ зүйлийн (a)(1), (2) болон (3)-ыг дагаж мөрдөхгүй байж болно.</p>	<p>3/ үнэмлэх гэрчилгээгээр олгогдсон эрх, хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаанд оролцох; ба</p> <p>4/ <u>планер</u>ын хувьд тогтоогдсон стандарт, журмыг баримтлах.</p> <p>(б) Эрх бүхий байгууллагаас томилогдсон багш нисгэгчийн шууд хяналтанд нислэг үйлдэх аливаа этгээд энэ зүйлийн (a)-гийн 1/, 2/ ба 3/-т заасан шаардлагыг үл харгалзан <u>планера</u>ар нислэг үйлдэж болно.</p>	
<p><b>104.6. Глайдерын ажилтан (шилжилт)</b></p> <p><b>(a)</b> Глайдерын нисгэгч нь дараах үнэмлэх болон зэрэглэл эзэмших үүрэгтэй:</p> <p>(1) глайдерын сурагч;</p> <p>(2) глайдерын мэргэшсэн нисгэгч;</p> <p>(3) хөөргөх нэмэлт төхөөрөмжийн баталгаажуулсан тэмдэглэл;</p> <p>(4) зорчигч тээвэрлэх эрх;</p> <p>(5) С-категорийн глайдерын Сургагч-нисгэгч;</p> <p>(6) В-категорийн глайдерын Сургагч-нисгэгч;</p> <p>(7) А-категорийн глайдерын Сургагч-нисгэгч;</p> <p>(8) хөөргөх нэмэлт төхөөрөмжийн зааварчилгааны баталгаажуулсан тэмдэглэл;</p> <p>(9) хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөх эрх;</p> <p>(10) IFR-аар нисэх эрх.</p> <p><b>(b)</b> Глайдерын инженер нь дараах зөвшөөрөл болон зэрэглэлийг эзэмших үүрэгтэй:</p> <p>(1) ангилал-2 зөвшөөрөл;</p> <p>(2) ангилал-3 зөвшөөрөл, W, M, болон P дэд зэрэгтэй;</p> <p>(3) ангилал-4 зөвшөөрөл, W, M, болон P дэд зэрэгтэй;</p> <p>(4) С-зэрэглэл;</p> <p>(5) S-зэрэглэл;</p> <p>(6) R-зэрэглэл;</p> <p>(7) E-зэрэглэл, E2, E3 болон E4 дэд зэрэгтэй.</p>		<p>- Part 19-өөс шилжүүлсэн</p>
<p><b>104.7. Туршилтын нислэг</b></p> <p>(a) ИНД-91.101(с)(4)-т заасныг үл харгалзан, <u>глайдерын</u> нисгэгчийн хүчинтэй үнэмлэх болон зохих маягийн зэрэглэл эзэмшигч нь ИНД-91.101(с)-д заасны дагуу <u>глайдерт</u> нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, шинэчлэх, эсхүл сэргээх шаардлагыг хангаж байгааг үзүүлэх зорилгоор үйлдэх</p>	<p><b>104.7. Шалгах нислэг</b></p> <p>(a) <u>Планерын</u> нисгэгчийн гэрчилгээтэй болон зохих зэрэглэлтэй этгээд нь ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, <u>планерын</u> нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, эсхүл шинэчлэх зорилгоор шалгах нислэг үйлдэж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>шалгах нислэгт <a href="#">глайдерын</a> даргын үүрэг гүйцэтгэж болно.</p> <p>(b) ИНД-91.613(a)(1)-д заасныг үл харгалзан, <a href="#">глайдерын</a> нисгэгчийн үнэмлэх болон зохих маягийн зэрэглэл эзэмшигч нь, хэрэв тухайн <a href="#">глайдерын</a> үйл ажиллагааг нислэгт шалгах шаардлагатай бол, ИНД-91.613-ын дагуу <a href="#">глайдерын</a> үйл ажиллагааг шалгах нислэг үйлдэж болно.</p>	<p>(б) <a href="#">Планерын</a> нисгэгчийн гэрчилгээтэй болон зохих зэрэглэлтэй этгээд нь ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, <a href="#">планерын</a> техник үйлчилгээний чанар нислэгийн үзүүлэлтэд тохирч байгаа эсэхийг шалгах зорилгоор шалгах нислэг үйлдэж болно.</p>	
<p><b>104.9. <a href="#">Нислэгийн заавар</a></b> ИНД-91.111(2)-т заасныг үл харгалзан, дараах тохиолдолд аливаа этгээд нь <a href="#">нислэгийн зааврыг</a> авч явахгүйгээр, <a href="#">глайдераар</a> үйл ажиллагаа эрхэлж болно хэрэв:</p> <p>(1) тухайн <a href="#">нислэгийн зааврыг</a> нислэгийн урьдчилсан төлөвлөлтийн явцад нисгэгч хэрэглэх боломжтой бол;</p> <p>(2) бүхээгийн мэдээлэл (decal) нь тухайн <a href="#">глайдерын</a> үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэхэд нисгэгчид хэрэгтэй ишлэл болж чадах бол.</p>	<p><b>104.9. <a href="#">Нислэг ашиглалтын заавар</a></b> (a) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, аливаа этгээдийг дараах нөхцөлд <a href="#">Нислэг ашиглалтын заавар</a> гүйгээр <a href="#">планераар</a> нислэг үйлдэхийг зөвшөөрч болно:</p> <p>1/ нисгэгч нь <a href="#">Нислэг ашиглалтын заавартай</a> нислэгийн урьдчилсан төлөвлөлтийн явцад танилцсан бол;</p> <p>2/ нисгэгчийн бүхээгт аюулгүй ажиллагаанд шаардагдах бүх мэдээллүүд тавигдсан бол.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Нислэг ашиглалтын заавар- нислэгийн заавар болсон.</p>
<p><b>104.11. Хэрэглэлийн дуураймал нислэг</b> ИНД-91.125(a)(1)-д заасныг үл харгалзан, <a href="#">глайдерын</a> нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хэрэглэлийн дуураймал нислэг үйлдэх зорилгоор <a href="#">глайдерт</a> аюулгүй байдлын нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.</p>	<p><b>104.11. Хэрэглэлийн дуураймал нислэг</b> (a) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, <a href="#">планерын</a> нисгэгчийн гэрчилгээ эзэмшигч нь <a href="#">планерт</a> хэрэглэлийн дуураймал нислэгийн аюулгүй ажиллагаа хариуцсан нисгэгчээр нислэг үйлдэж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>104.13. Газрын дохио</b> Хэрэв <a href="#">глайдерын</a> нислэгийн үйл ажиллагаа хийгдэж байгааг газрын дохио ашиглан үзүүлж байгаа бол, тухайн газрын дохио нь хөөрөлт болон буулт үйлдэх чиглэлийг заасан цагаан өнгийн сумнаас бүрдэнэ.</p>	<p><b>104.13. Газар дахь дохио</b> (a) Хэрэв <a href="#">планерын</a> нислэгийн үед газрын дохио шаардлагатай бол <a href="#">планерын</a> хөөрөх, буух чиглэлийг заасан цагаан өнгийн том суман дохиог хэрэглэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>В Бүлэг - Нислэгийн дүрэм</b></p>	<p><b>Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЖУРАМ</b></p>	
<p><b>104.51. <a href="#">Хөдөлгөөний давуу эрхийн дүрэм</a></b> (a) ИНД-91.229(b)-д заасныг үл харгалзан, өндөрлөгөөс халин нисэж (soaring ridge) байгаа <a href="#">глайдерын</a> нисгэгчийг, тухайн <a href="#">глайдерын</a> баруун гар талд өндөрлөг байгаа бол, түүний эгц урдаас өөр <a href="#">глайдер</a> ойртох үед баруун тийш эргэхийг шаардахгүй.</p> <p>(b) ИНД-91.229(d)-д заасныг үл харгалзан, өндөрлөгөөс халин нисэж байгаа <a href="#">глайдерыг</a> гүйцэж түрүүлэх <a href="#">глайдерын</a> нисгэгч нь гүйцэгдэж байгаа глайдерыг өндөрлөгтэй талаар нь гүйцэж түрүүлнэ.</p>	<p><b>104.51. <a href="#">Нислэгийн хөдөлгөөнд оролцох</a></b> (a) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, <a href="#">планерын</a> нислэгийн үед баруун гар талд нь уулын хэц байгаа тохиолдолд, <a href="#">планерын</a> эгц урдаас өөр <a href="#">планер</a> ойртох тохиолдолд түүнд зам тавьж баруун гар тал руу эргэхийг энэ дүрмээр шаардахгүй.</p> <p>(б) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, <a href="#">планер</a> нь уулын хэц дээгүүр нисч байхдаа өөр <a href="#">планерыг</a> гүйцэж түрүүлэх тохиолдолд уулын хэц талаар тойрч түрүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“<a href="#">планер</a>” гэснийг “<a href="#">глайдер</a>” гэж <a href="#">өөрчлөгдсөн</a></p>

<p>(с) ИНД-91.229(f)-д заасныг үл харгалзан, хоёр глайдер төгсгөлийн буулт хийх ойртолт үйлдэж байгаа тохиолдолд, илүү үзүүлэлттэй <u>глайдерын</u> нисгэгч нь бага үзүүлэлттэй <u>глайдерт</u> зам тавьж өгнө.</p>	<p>(в) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, хоёр <u>планер</u> буултын ойртолтыг зэрэг үйлдэж байгаа тохиолдолд илүү үзүүлэлттэй <u>планер</u> нь бага үзүүлэлттэй <u>планертаа</u> зам тавьж өгнө.</p>	
<p><b>104.53. Хэрэглэлийн <u>нислэгийн</u> цаг уурын нөхцөл</b> ИНД-91.301-д заасныг үл харгалзан, тухайн <u>глайдерын</u> нисгэгч нь хэрэв тухайн нислэгийг дараах нөхцөлд үйлдэж байгаа бол хэрэглэлийн <u>нислэгийн</u> цаг уурын нөхцөлд (IMC), ИНД-91-ийн F Бүлгийн шаардлагыг мөрдөхгүй нисч болно:</p> <p><u>(1) үүлэн дотор нислэг үйлдэхээр тогтоосон хязгаарлалттай бүсэд</u>; эсхүл</p> <p>(2) <u>G ангиллын</u> агаарын зайд, үүлэн дотор нислэг үйлдэхээр санал болгосон бүсэд, эсхүл түүний ойролцоо мэдэгдэж байгаа IFR-ийн хөдөлгөөн байхгүй болохыг тухайн нисгэгч зохих НХҮ-ний нэгжээс 15 минутаас ихгүй үечлэлтэй мэдээлэл авч баталгаажуулдаг бол.</p>	<p><b>104.53. Хэрэглэлийн <u>нислэгийн</u> цаг уурын нөхцөл</b> (а) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, ИНД-91-ийн E Бүлгийн шаардлагыг дагаж мөрдөлгүйгээр, <u>планерын</u> нисгэгч нь дараах тохиолдолд хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөлд <u>планераар</u> нислэг үйлдэж болно:</p> <p><u>1/ ИНЕГ-аас үүлэн дунд нислэг үйлдэх зөвшөөрөл олгосон; эсхүл</u></p> <p>2/ үүлэн дунд нислэг үйлдэхэд зориулагдсан хязгаарлагдмал бүс тогтоогдсон; эсхүл</p> <p>3/ үүлэн дунд нислэг үйлдэхэд зориулагдсан хязгаарлагдмал бүс үүлэн дундах нислэг үйлдэх газар нутаг дээр буюу ойролцоо ХНД-ээр үйлдэгдэх нислэгийн хөдөлгөөнгүй гэсэн баталгааг ойролцоох нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас 15 минут тутамд мэдээлэл авч байгаа бол G <u>ангиллын</u> агаарын зайд үйлдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>104.55. <u>Үүлнээс зай барих</u></b> ИНД-91.301(а)(2)-т заасныг үл харгалзан, 900 м-ээс (3000 ft) дээш түвшинд болон 300 м-ээс (1000 ft) дээш өндөрт, гэхдээ 3300 м-ээс (11 000 ft) доош түвшинд нисэж байгаа <u>глайдерын</u> нисгэгч нь E, эсхүл <u>G ангиллын</u> агаарын зайд үүлэн доогуур, түүнээс 150 м-ээс (500 ft) ойрхон нисэхгүй.</p>	<p><b>104.55. <u>Үүлэн доогуурх нислэг</u></b> (а) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, E ба G <u>ангиллын</u> агаарын зайд нислэг үйлдэх <u>планерын</u> нисгэгч нь 900 м (3000 фут)-ийн үнэмлэхүй өндрөөс дээш өндөрт болон 300 м (1000 фут)-ийн харьцангуй өндрөөс дээш өндөрт, харин 3300 м (11000 фут)-ийн үнэмлэхүй өндрөөс доош өндөрт нислэг үйлдэхдээ үүлний доод суурьд 150 м (500 фут)-ээс ойргүй нислэг үйлдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>104.57. <u>Түлшний</u> шаардлага</b> ИНД-91.305(а)-ийн шаардлага нь <u>глайдерын</u> нисгэгчид хамаарахгүй.</p>	<p><b>104.57. <u>Шатахууны</u> шаардлага</b> (а) ИНД-91-ийн холбогдох шаардлага нь <u>планерын</u> нисгэгчид хамаарахгүй.</p>	<p>-“Шатахуун” гэснийг “түлш” гэж</p>
<p><b>104.59. <u>Минимум өндөр</u></b> ИНД-91.311(а)(2)-т заасныг үл харгалзан, <u>глайдерын</u> нисгэгч нь тухайн гадаргуугаас 150 м-ээс (500 ft) нам өндөрт, дараах нөхцөлд үйл ажиллагаа гүйцэтгэж болно:</p>	<p><b>104.59. <u>Хамгийн нам өндөр</u></b> (а) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, <u>планерын</u> нисгэгч нь дараах тохиолдолд газрын гадаргуугаас дээш 150м (500 фут)-ээс нам өндөрт</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(1) өндөрлөгөөс халин нисэх нислэгийн (ridge soaring) хувьд, хэрэв газарт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахааргүй бол; эсхүл</p> <p>(2) хэрэв <u>глайдерын</u> <u>Сургагч-нисгэгч</u> хөөргөх төхөөрөмжийн татгалзлын сургалт дадлага зохион байгуулж байгаа бол.</p>	<p>нислэг үйлдэж болно:</p> <p>1/ хэрэв газар дээрх хүн буюу өмч хөрөнгөнд хохирол учруулахгүй бол уулын хэцээс хөөрөх; эсхүл</p> <p>2/ хэрэв <u>планерын</u> зааварлагч хөөрөлтийн үед гарч болох алдаа, дутагдлын талаар сургалт дадлага явуулж байгаа бол.</p>	
<p><b>104.61. <u>VFR-ийн аяллын болон нислэгийн түвшин</u></b> ИНД-91.313-д заасныг үл харгалзан, <u>глайдерын</u> нисгэгчээс, тухайн аяллын түвшний, эсхүл нислэгийн түвшний соронзон чиглэлийг барихыг шаардахгүй.</p>	<p><b>104.61. <u>ИХНД-ээр үйлдэх чиг шулуун нислэгийн өндөр</u></b> (а) ИНД-91-ийн холбогдох шаардлагыг үл харгалзан, нислэгийн соронзон чиглэлд чиг шулуун нислэгийн өндөр, эсхүл нислэгийн цувааг барих шаардлагагүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>С Бүлэг-Төхөөрөмж болон техник үйлчилгээний шаардлага</b></p>	<p><b>В БҮЛЭГ. <u>ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШААРДЛАГА</u></b></p>	
<p><b>104.101. Агаарын хөлгийн төхөөрөмж</b> Дараах төхөөрөмж болон ажиллагаатай хэрэглэлээр тоноглогдсоноос бусад тохиолдолд, аливаа этгээд нь <u>глайдераар</u> үйл ажиллагаа эрхлэхгүй:</p> <p>(1) агаарын хурдны заах хэрэглэл;</p> <p>(2) барометрийн даралтын тохируулгатай, даралтаар өндөр хэмжигч;</p> <p>(3) соронзон луужин;</p> <p>(4) суудал бүрд аюулгүй байдлын бэхэлгээ;</p> <p>(5) анхны тусламжийн иж бүрдэл;</p> <p>(6) <u>моторт-глайдерын</u> хувьд:</p> <p>(i) <u>түлшний</u> үндсэн сав бүрд хэмжүүр;</p> <p>(ii) хоёр тактын хөдөлгүүрээс бусад хөдөлгүүрийн хувьд, тосны даралт хэмжигч, эсхүл анхааруулах дохионы хэрэгсэл;</p> <p>(iii) тахометр, эргэлтийн хурдны заах хэрэглэл, эсхүл хөдөлгүүр бүрд эргэлт мэдрэгч гэрэл;</p> <p>(7) хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөлд (IMC) үйлдэх нислэгийн хувьд:</p> <p>(i) босоо хурд хэмжигч (variometer);</p> <p>(ii) эргэлт болон гулгалт заах хэрэглэл (turn-slip), эсхүл авиагоризонт (artificial horizon);</p> <p>(iii) ИНД-91-ийн Хавсралт А, А.9(с)-гийн шаардлагыг хангасан, зохих НХҮ-ний нэгжтэй холбоо барих чадвартай, нисэхийн радио</p>	<p><b>104.101. Агаарын хөлгийн тоног төхөөрөмж</b> (а) Дараах хэрэглэл, тоног төхөөрөмжгүй <u>планераар</u> нислэг үйлдэхийг хориглоно:</p> <p>1/ нислэгийн хурд заагч, ба</p> <p>2/ агаарын даралтыг мэдрэмтгий өндөр хэмжигч, ба</p> <p>3/ соронзон луужин, ба</p> <p>4/ суудал бүрийн хамгаалах бэхэлгээ бүс, ба</p> <p>5/ эмийн сан, ба</p> <p>6/ хөдөлгүүрт <u>планерын</u> хувьд –</p> <p>6.1 <u>шатахууны</u> бак тус бүрийн хэмжүүр;</p> <p>6.2 маслын даралтын хэмжүүр ба хөдөлгүүрийн дохиоллын төхөөрөмж;</p> <p>6.3 хөдөлгүүрийн эргэлт заагч тахометр, эсхүл хөдөлгүүр хэт эргэлтийг дохиологч гэрэл;</p> <p>7/ хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл (IMC)-д үйлдэх нислэгийн хувьд:</p> <p>7.1 вариометр;</p> <p>7.2 халтиргаа заагч;</p> <p>7.3 нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба /ATS/-тай харилцах радио холбооны станц.</p>	

холбооны дамжуулагч-хүлээн авагч хэрэгсэлтэй байх.

(б) ИНД-91-ийн шаардлагыг үл харгалзан, дараах тоног төхөөрөмжүүд нь планерт хэрэглэх радио холбооны төхөөрөмжийн шаардлагыг хангасан байх бөгөөд тэдгээрийг батлагдсан зааврын дагуу суурилуулан, хүлээн авах антенныг зохих долгион дээр тохируулсан байна:

- 1/ Icom ICA 2
- 2/ Icom IC-A20
- 3/ King KX99
- 4/ Narco HT830

-Amend.2-оор заалтыг хассан

**104.103. Техник үйлчилгээний ерөнхий шаардлага Глайдерын үйл ажиллагаа эрхлэгч дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:**

- (1) тухайн глайдерт нислэгт тэнцэх нөхцөлийг хангасан техник үйлчилгээ хийсэн байх;
- (2) ИНД-39-д заасан шаардлагын дагуу холбогдох бүх НТЧ-ын удирдамжийг биелүүлсэн байх;
- (3) тухайн глайдерт дараах үзлэг шалгалт хийсэн байх:
  - (i) энэ Бүлгийн шаардлагын дагуу;
  - (ii) ИНД-91-ийн G Бүлэгт заасан холбогдох шаардлагын дагуу;
- (4) үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний зааврын НТЧ-ын хязгаарлалтад заасан хатуу цагтай эд ангийг солих хугацаа, үзлэг шалгалтын үечлэл болон холбогдох журам, эсхүл тухайн глайдерт зориулан гаргасан НТЧ-ын хадгалалтын зааварчилгаа хэрэгжсэн байх;
- (5) шаардлагатай үзлэг шалгалтын хооронд, гэмтэл дутагдлыг ИНД-43-ын дагуу зассан байх.

**104.103. Техник үйлчилгээний ерөнхий шаардлага**

- (а) Планераар үйл ажиллагаа гүйцэтгэх этгээд нь дараах зүйлсийг бататгана:
- 1/ планер нь нислэгт тэнцэх чадвартай гэдгийг;
  - 2/ ИНД-39-ийн дагуу гарсан Нислэгт тэнцэх чадварын холбогдох бүх удирдамжууд гүйцэтгэгдсэн гэдгийг;
  - 3/ тухайн агаарын хөлгийн хувьд үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний заавар, эсхүл гарын авлагад заагдсан хугацаат үзлэг шалгалт, нислэгт тэнцэх чадварын хязгаарлалтад хамаарах журмууд мөрдөгдөж байгаа гэдгийг;
  - 4/ шаардлагатай үзлэг, дутагдал засах ажиллагаа ИНД-43-ын дагуу хийгдсэн гэдгийг.

- Amend.5-аар нэмэгдсэн

**104.105. Техник үйлчилгээний үзлэг шалгалт Глайдер нь өмнөх 12 сарын хугацаанд дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь тухайн глайдераар үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:**

- (1) 104.107-гийн дагуу шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу үзлэг шалгалт хийгдсэн болон ИНД-43-ын дагуу ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлсэн байх; эсхүл
- (2) ИНД-21-ийн дагуу НТЧ-ын гэрчилгээ олгох үзлэг

**104.105. Техник үйлчилгээний үзлэг**

- (а) Өмнөх 12 хуанлийн сарын хугацаанд дараах шаардлага хангагдаагүй планерыг аливаа этгээд нислэгийн үйл ажиллагаанд оролцуулж болохгүй:
- 1/ энэ дүрмийн 104.107-д заасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу үзлэг хийгдэж ИНД-43-т заасны дагуу үйлчилгээнээс чөлөөлөгдсөн байх;
  - 2/ ИНД-21-ийн дагуу НТЧ-ын гэрчилгээ олгох үзлэг

-Орчуулга, найруулга зассан

шалгалтад тэнцсэн байх.	хийгдсэн байх.	
<p><b>104.107. Техник үйлчилгээний хөтөлбөр</b>  <u>Глайдерын</u> үйл ажиллагаа эрхлэгч нь, хүчилсэн бүтэц хөдөлгүүр, эсхүл сэнс, бүрдэл хэсэг, авран хамгаалах болон ослын төхөөрөмжийг багтаасан, тухайн <u>глайдерт</u> ИНД-91-ийн G Бүлэгт заасан холбогдох шаардлага болон дараах баримт бичгийн дагуу техник үйлчилгээ хийх үүрэгтэй:</p> <p>(1) үйлдвэрлэгчийн зөвлөсөн хүчинтэй техник үйлчилгээний хуваарь; эсхүл</p> <p>(2) техник үйлчилгээний хөтөлбөр:</p> <p>(i) 104.109-ийн дагуу глайдерын байгууллагаар зөвшөөрөгдсөн ба холбогдох журам нь тухайн <u>глайдерын</u> байгууллагын Ерөнхий зааварт тусгагдсан; эсхүл</p> <p>(ii) 104.109-д заасны дагуу <u>Даргын</u> баталсан.</p>	<p><b>104.107. Техник үйлчилгээний хөтөлбөр</b>  (a) <u>Планер</u> ашиглагч нь <u>планер</u>ын их бие, сэнс, аваарын тоног төхөөрөмж, эд анги, хөдөлгүүрт дараах хөтөлбөрийн дагуу техник үйлчилгээ хийнэ:</p> <p>1/ үйлдвэрлэгчээс зөвлөмж болгосон техник үйлчилгээний хүчин төгөлдөр хөтөлбөр; эсхүл</p> <p>2/ эрх бүхий байгууллагаар хянан батлагдсан болон энэ дүрмийн 104.109-ийн дагуу <u>ИНЕГ</u>-аар батлагдсан, <u>планер</u> эзэмшигчийн боловсруулсан техник үйлчилгээний хөтөлбөр.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“ИНЕГ”гэснийг “Дарга” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>104.109. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах ба зөвшөөрөл олгох</b>  (a) Энэ дүрмийн 104.107(2)-ын дагуу Техник үйлчилгээний хөтөлбөрийн <u>хүрээнд глайдерт техник үйлчилгээ хийхийг хүсэж байгаа глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь глайдерын байгууллагаас зөвшөөрөл авахаар, эсхүл Даргаар</u> батлуулахаар <u>тухайн хөтөлбөрийг</u> бичгээр хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(b) Энэ дүрмийн 104.107(2)-ын дагуу шаардсан хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:</p> <p>(1) тухайн глайдерыг сургалтын үйл ажиллагаанд ашиглах эсэх тухай мэдэгдэл;</p> <p>(2) тухайн хөтөлбөрт санал болгосон үзлэг шалгалтыг ашиглалтын хугацаагаар, хуанлийн хугацаагаар, эсхүл тэдгээрийн <u>хосолмол байдлаар</u> хийх хуваарь;</p> <p>(3) тухайн <u>глайдерын</u> хийц, загварт тохирсон шаардлагатай тест болон шалгалтыг багтаасан, техник үйлчилгээг хийх зааварчилгаа болон журам. Тухайн зааварчилгаа болон журамд үзлэг шалгалт хийх шаардлагатай авран хамгаалах болон ослын төхөөрөмжийг багтаасан, хүчилсэн бүтэц, хөдөлгүүр, сэнс болон бүрдэл хэсгийн эд анги болон байрлалыг</p>	<p><b>104.109. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах</b>  (a) Энэ дүрмийн 104.107-гийн 2/-т заагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийг хянан батлуулахын тулд уг хөтөлбөрийг бичгээр үйлдэж <u>эрх бүхий байгууллага, эсхүл ИНЕГ-ын даргад</u> ирүүлнэ.</p> <p>(б) Энэ дүрмийн 104.107-гийн 2/-т заасан хөтөлбөр нь дараах зүйлсийг агуулсан байна:</p> <p>1/ агаарын хөлгийг сургалтанд ашиглах, эсхүл үгүй эсэхийг тодорхойлсон байх;</p> <p>2/ хөтөлбөрт тусгагдсан үзлэг шалгалтыг ашиглалтын цаг буюу хуанлийн хугацаа, эсхүл тэдгээрийн <u>нийлмэл байдлаар</u> гүйцэтгэх хуваариуд;</p> <p>3/ <u>планер</u>ын төрөл, загварын хувьд шаардлагатай үзлэг шалгалтыг хамарсан техник үйлчилгээний заавар журмууд; тухайн заавар журамд <u>планер</u>ын их бие, мотор, сэнс, бүрэлдэхүүн бусад хэсэг, авран хамгаалах тоног төхөөрөмжийн үзлэг шалгалтыг нарийвчлан заасан байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

дэлгэрэнгүй заасан байх ёстой.

(с) Хэрэв глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь [энэ зүйлийн \(а\)-ийн дагуу зөвшөөрсөн, эсхүл баталсан](#) Техник үйлчилгээний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах бол, тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь шинэ хөтөлбөрийн хүрээнд хийх үзлэг шалгалтын үлдэгдэл хугацааг тодорхойлохдоо, өмнөх хөтөлбөрийн хүрээнд хуримтлагдсан ашиглалтын хугацаа (time-in-service), эсхүл хуанлийн хугацааг тооцох үүрэгтэй.

(д) Хэрэв глайдерын байгууллага, эсхүл [Дарга тухайн нэмэлт өөрчлөлт нь уг хөтөлбөрийн үр дүнтэй байдлыг хадгалахад шаардлагатай болохыг тогтоосон бол](#), 104.107(2)-ын дагуу шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд [глайдерт](#) техник үйлчилгээ хийж байгаа глайдерын үйл ажиллагаа эрхлэгч нь, тухайн хөтөлбөрийг зөвшөөрсөн [глайдерын](#) байгууллагын, эсхүл Даргын өгсөн зааварчилгааны дагуу хөтөлбөртөө нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэгтэй.

(в) Техник үйлчилгээний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулахдаа өмнөх хөтөлбөрт заагдсан техник үйлчилгээний үечлэл, хугацааг алдагдуулахгүй байлгана.

(г) Эрх бүхий байгууллага, эсхүл [ИНЕГ-аас](#) энэ дүрмийн 104.107–гийн 2/-т заагдсан техник үйлчилгээний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл [планер](#) эзэмшигч нь уул нэмэлт өөрчлөлтийг оруулна.

#### 104.111. Нөөц

##### 104.113. Техникийн бүртгэлийн [дэвтэр \(TLB\)](#)

(а) [Глайдерын](#) үйл ажиллагаа эрхлэгч нь дараах мэдээллийг агуулсан, агаарын хөлгийн TLB хөтөлнө:

- (1) тухайн [үйл ажиллагаа эрхлэгчийн](#) нэр болон хаяг;
- (2) тухайн [глайдерын](#) ашиглалтад хэрэглэж байсан техник үйлчилгээний хөтөлбөрийг таньж тогтоох мэдээлэл;
- (3) дараагийн үзлэг шалгалтын үлдэгдэл цаг болон үзлэг шалгалт хийх огноог таньж тогтоох мэдээллийг багтаасан, тухайн глайдерын үзлэг шалгалтын нөхцөл байдлын мэдэгдэл;
- (4) сүүлчийн НТЧ-ын жилийн дүгнэлт хийсэн огноо;
- (5) өдөр тутмын ниссэн цагийг багтаасан ашиглалтын нийт цаг;
- (6) өдөр тутмын үзлэг хийсэн нисгэгчийн гарын үсэг;
- (7) тохируулга хийсний дараах эхний болон хоёр дахь хяналтын үзлэг хийсэн гарын үсэг;
- (8) нислэгийн үед, эсхүл нислэгийн дараа нисгэгчийн

#### 104.111. Нөөц

##### 104.115. Техникийн бүртгэл [хөтлөлт](#)

(а) [Планер](#)аар нислэг үйлдэж байгаа этгээд нь [планерын](#) техникийн бичиг баримтын бүртгэл хөтлөх ба уг бүртгэлд дараах зүйлсийг тусгана:

- 1/ [нислэг үйлдэгчийн](#) нэр, хаяг;
- 2/ [планерт](#) хийгдсэн техник үйлчилгээний хөтөлбөрүүд;
- 3/ [планерт](#) үзлэг хийсэн байдал, дараах үзлэгийн хугацаа, тухайн үзлэгийн он, сар, өдөр;
- 4/ нислэгт тэнцэх чадварын жил тутмын үзлэг, хамгийн сүүлд шалгалт үзлэг хийсэн он, сар, өдөр;
- 5/ нийт ашиглалтын хугацаа болон өдөрт ниссэн цаг;
- 6/ өдөр тутмын нислэг үйлдсэн нисгэгчийн гарын үсэг;
- 7/ тоноглолын анхдагч ба хоёрдогч шалгалт үзлэг хийсэн тэмдэглэл, гарын үсэг;
- 8/ нислэгийн үед, эсхүл дараа гэмтэл, эвдрэлийн

-104.115-д байгаа



<p>илрүүлсэн гэмтэл;</p> <p>(9) <u>хуваарьт үзлэг шалгалтын хооронд</u> илэрсэн гэмтэл дутагдлыг зассан дэлгэрэнгүй мэдээлэл болон тухайн гэмтлийг арилгасны дараа ашиглалтад <u>шилжүүлсэн</u> гэрчилгээ;</p> <p>(10) ИНД-91.537-гийн дагуу ажиллагаагүй байж болох нь зөвшөөрөгдсөн төхөөрөмжийг багтаасан, хойшлуулсан дутагдлыг арилгах ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл.</p> <p>(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг TLB-д бүртгэх ба тухайн мэдээлэл хүчинтэй болохыг бататгана, гэхдээ өдөр тутмын ниссэн цаг болон нийт ашиглалтын цагийг өдөр тутмын нислэгийн хуудсанд байнгын арилдаггүй байдлаар тусад нь бичилт хийж оруулна.</p>	<p>талаарх нисгэгчийн тэмдэглэл;</p> <p>9/ <u>хоёр үзлэгийн хооронд</u> гарсан эвдрэл гэмтлийг засварласан тухай тэмдэглэл, засварын дараа ашиглалтанд <u>өгсөн</u> баталгаа.</p> <p>10/ ИНД-91-д заасны дагуу ажиллагаагүй гэж тооцогдсон тоног төхөөрөмжийн засварын тухай нарийвчилсан тодорхойлолт.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг техникийн бүртгэлийн журналд тэмдэглэсэн байх ба өдөр тутмын нислэгийн хуудсанд тэмдэглэгдэх нислэгийн цаг болон нийт ашиглалтын цагаас бусад мэдээ нь бодит цаг үеийн мэдээлэл байна.</p>	
<p><b>104.115. Нисгэгчийн гүйцэтгэх техник үйлчилгээ</b></p> <p>(a) ИНД-43.51(b)-д заасныг үл харгалзан, <u>глайдерын</u> нисгэгчийн хүчинтэй үнэмлэх эзэмшдэг этгээд нь, хэрэв тухайн <u>глайдерын</u> өмчлөгч, эсхүл <u>глайдерын</u> үйл ажиллагаа эрхлэгч бол, ИНД-43-ын Хавсралт А-ийн А.1 болон А.2-д заасан техник үйлчилгээг хийж болно.</p> <p>(b) ИНД-43.101(a)(б)-д заасныг үл харгалзан, энэ зүйлийн (a)-д заасны дагуу <u>глайдерт</u> техник үйлчилгээ хийж байгаа этгээд нь, техник үйлчилгээг хийсний дараа тухайн <u>глайдерыг ашиглалтад шилжүүлэхээр</u> гэрчилгээжүүлж болно.</p>	<p><b>104.117. Нисгэгчийн гүйцэтгэх техник үйлчилгээ</b></p> <p>(a) ИНД-43-ын шаардлагыг үл харгалзан, <u>планерын</u> нисгэгч нь тухайн <u>планерыг</u> эзэмшигч болон ашиглагч бол ИНД-43-ын Хавсралт А-д заасан техник үйлчилгээг гүйцэтгэж болно.</p> <p>(б) ИНД-43-ын шаардлагыг үл харгалзан, <u>планерын</u> нисгэгч нь энэ хэсгийн (a)-д заасан техник үйлчилгээг гүйцэтгэсний дараа тухайн <u>планерыг техник үйлчилгээнээс гарган</u> баталгаажуулж болно.</p>	<p>-104.113 –ийг дэлгэрэнгүй болгосон</p> <p>-Release to service-техник үйлчилгээнд гаргах гэдгийг ашиглалтад шилжүүлэх болгосон.</p>

Дүрмийн боловсруулалтын хэлтэс